



2017 оны 01 дүгээр сарын 06
№ 01 /958/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

2

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг

6

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

10

Хуулийн төсөл
буцаах тухай

Дипломат дээд цол
олгох тухай

Гемодиализ эмчилгээний
хүртээмжийг нэмэгдүүлэх
тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|----|----------------------------|-----------|---|
| 1. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 80 | 2 |
|----|----------------------------|-----------|---|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|--|------------|----|
| 2. | Зарим хүмүүсийг шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 171 | 2 |
| 3. | Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 172 | 3 |
| 4. | Дипломат дээд цол олгох тухай | Дугаар 173 | 6 |
| 5. | Цэргийн дээд цол олгох тухай | Дугаар 179 | 7 |
| 6. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 180 | 8 |
| 7. | Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 181 | 8 |
| 8. | Зэрэг дэв олгох тухай | Дугаар 182 | 9 |
| 9. | Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 183 | 9 |
| 10. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цом гардуулах тухай | Дугаар 185 | 10 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|--|------------|----|
| 11. | Гемодиализ эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх тухай | Дугаар 159 | 10 |
| 12. | “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 169 | 11 |
| 13. | Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 186 | 13 |
| 14. | Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2017 оны хэмжээг тогтоох тухай | Дугаар 197 | 14 |
| 15. | Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 215 | 15 |



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Г.Мөнхцэцэг, Я.Содбаатар, Ц.Цогзолмаа, Н.Энхболд нараас 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон түүнийг дагалдан өргөн мэдүүлсэн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Шаравын Баттогтохыг Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны



шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Ванд-Очирын Цэцэнбилэгийг Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Дашдоржийн Мөнхөөг Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Бадарчийн Сайханцэцэгийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар
хот

**Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах
шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн
албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан хүмүүсийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2016 оны 12 дугаар сарын 26-ны
өдрийн 172 дугаар зарлигийн хавсралт

Нэг. Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:

1.Санжаагийн Амардэлгэрийг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

2.Бавалын Баатарыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

3.Мянгаагийн Баясгаланг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

4.Батбаярын Цолмонбаатарыг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

5.Нямдоржийн Одонтуулыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

6.Мөнхбаярын Алдарыг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

7.Батбаярын Мөнхбаярыг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

8.Цэвэгдоржийн Оюунчимэгийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

9.Бадарчийн Сайханцэцэгийг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

10.Осордэлэгийн Жанчивнямбууг Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

11.Нямжавын Гэрэлтуяаг Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

Хоёр. Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд:

1.Барнямын Мөнхтуяаг Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

2.Дашийн Мөнхбүрэнг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

3.Хөхөөгийн Санжидмааг Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

4.Пүрэвдоржийн Баясгаланг Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

5.Доржийн Батцэнгэлийг Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд.

Гурав. Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:

1.Түндэвийн Даваасүрэнг Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

2.Солтанмуратын Өмирбекийг Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

3.Магнайбаярын Мөнхдавааг Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

4.Ёндонгийн Бямбацэрэнг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;



5. Шаравын Баттогтохыг Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

6. Нэргүйн Батчимэгийг Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

7. Лхүндэвийн Наранбаярыг Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

8. Тогооборын Бямбажавыг Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

9. Жигдэнгийн Баттогтохыг Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

10. Нямдоржийн Насанжаргалыг Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

11. Данзангийн Эрдэнэбилэгийг Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

12. Батжаргалын Батзоригийг Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

13. Нямжавын Туяаг Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

14. Борын Дэнсмааг Хэнтийн аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

15. Батчулууны Сосорбарамыг Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

16. Зундуйн Хосбаярыг Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

17. Буурайн Баттөрийг Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

18. Оросоогийн Нарангэрэлийг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

Дөрөв. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд:

1. Ванд-Очирын Цэцэнбилэгийг Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

2. Дашдоржийн Мөнхөөг Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар
хот

Дипломат дээд цол олгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсад орчин цагийн дипломат алба үүсч хөгжсөний 105 жилийн ойг тохиолдуулан гадаад харилцааны салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, АСЕМ-ийн 11 дэх удаагийн дээд хэмжээний чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулахад онцгой хувь нэмэр оруулсан, гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг үнэлж дараах нэр бүхий албан хаагчдад дипломат дээд цол олгосугай.

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд цолоор:

Цэндийн Мөнх-Оргил	Монгол Улсын Гадаад харилцааны сайд
Цэрэндашийн Цолмон	Батлан Хамгаалахын сайд асан
Раднаабазарын Алтангэрэл	Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд
Шижээхүүгийн Одонбаатар	Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлтийн газрын захирал
Лувсанцэрэнгийн Оргил	АСЕМ-ын бэлтгэл ажлын албаны дарга
Намнангийн Нямжав	АСЕМ-ын бэлтгэл ажлын албаны зөвлөх
Отгоны Дамбийням	АСЕМ-ын бэлтгэл ажлын албаны зөвлөх
Гозонгийн Жаргалсайхан	АСЕМ-ын бэлтгэл ажлын албаны зөвлөх
Бадарчийн Сувд	АСЕМ-ын бэлтгэл ажлын албаны зөвлөх

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолоор:

Бадамдоржийн Батхишиг	Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
-----------------------	---



Цэдэндамбын Батбаяр	Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
Банзрагчийн Дэлгэрмаа	Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
Хишигдэлгэрийн Даваадорж	Монгол Улсаас Бельгийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
Сүрэнгийн Цоггэрэл	Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
Лхамсүрэнгийн Дүгэржав	Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
Долоонжингийн Идэвхтэн	Элчин сайд асан
Чимэддоржийн Агваандамдин	Ахмад дипломатч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Цэргийн дээд цол олгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1.7, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 182 дугаар зарлигаар батлагдсан Дээд офицерын албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал Дуламсүрэнгийн Даваад “Дэслэгч генерал”, Тагнуулын ерөнхий газрын тэргүүн дэд дарга, хурандаа Буянхүүгийн Доньжчинбууд “Бригадын генерал”, Хил хамгаалах ерөнхий газрын Ар тал, зэвсэглэл, инженер-техник эрхэлсэн орлогч, хурандаа Хожгорын Лхагвасүрэнд “Бригадын генерал”, Хил хамгаалах ерөнхий газрын захиргааны удирдлага эрхэлсэн орлогч, хурандаа Жамсрангийн Бямбасүрэнд “Бригадын генерал”,



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Цэвэгмидийн Амгаланбаярт “Бригадын генерал” цол тус тус олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 180

Улаанбаатар
хот

**Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Бямбын Мөнхтуяаг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 181

Улаанбаатар
хот

**Улсын ерөнхий прокурорын орлогчийн
албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын ерөнхий прокурорын санал болгож Улсын Их Хуралтай зөвшилцсөнөөр Баяраагийн Амгаланбаатарыг Монгол Улсын Ерөнхий прокурорын албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 182

Улаанбаатар
хот

Зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигаар батлагдсан “Прокурорын зэрэг дэв олгох дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч Баяраагийн Амгаланбаатарт Төрийн хууль цаазын шадар зөвлөх зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Гочоогийн Банзрагч, Бямбын Мөнхтуяа нарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 12 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 185

Улаанбаатар
хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цом гардуулах тухай тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 105 жилийн ойн өндөр чансаатай, хүчит 128 бөхийн барилдаанд түрүүлсэн Монгол Улсын арслан Рэнцэнбямбын Пүрэвдагвад Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цом гардуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар
хот

Гемодиализ эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.3, 24.6.7, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бөөрний хурц болон архаг дутагдалтай өвчтөнийг гемодиализ эмчилгээгээр тасралтгүй хангаж, хүртээмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тавигдах шаардлагыг хангасан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар уг эмчилгээг хийлгүүлэх тухай Эрүүл мэндийн яамны саналыг дэмжсүгэй.

2. Гемодиализ-бөөр орлуулах эмчилгээний төрөөс хариуцах төлбөрийн хэмжээг баталж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын

төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг нарт үүрэг болгосугай.

3. Гемодиализ эмчилгээний зардлыг төсвийн багцаасаа эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж байхыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт, эрүүл мэндийн даатгалын байгууллага болон гемодиализ эмчилгээ хийх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага хооронд гэрээ байгуулах замаар уг эмчилгээг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

А.ЦОГЦЭЦЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар
хот

“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн 3.1.2 дахь заалтын “30-50м² хүртэлх” гэснийг “70м² хүртэлх” гэж өөрчилсүгэй.

2. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын захиалгаар Улаанбаатар хот болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан 360 айлын орон сууцыг хавсралтад заасны дагуутөрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсүгэй.

3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээлийн төлбөрт шаардагдах 30,286.0(гучин тэрбум



хоёр зуун наян зургаан) сая төгрөгийг хянан тооцсоны үндсэн дээр улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусган шийдвэрлэж, зээлийн хүүгийн төлбөрийг орон сууцны түрээсийн төлбөрөөс бүрдүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД**

Г.МӨНХБАЯР

Засгийн газрын 2016 оны 169 дүгээр
тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ САНД
ШИЛЖҮҮЛЭХ ОРОН СУУЦНЫ ЖАГСААЛТ**

№	Байршил	Түрээсийн орон сууцны санд шилжүүлэх		1м ² талбайн худалдан борлуулах үнэ (мян.төг)	Нийт үнэ (сая.төг)
		орон сууцны тоо	талбайн хэмжээ (м ²)		
1	Дархан-Уул	69	3,251.36	1,280.0	4,161.7
2	Сэлэнгэ	12	640.57	1,250.0	800.7
3	Ховд	20	1,336.60	1,250.0	1,670.8
4	Увс	21	1,465.80	1,250.0	1,832.3
5	Хэнтий	24	1,603.92	1,250.0	2,004.9
6	Улаанбаатар	214	14,678.26	1,350.0	19,815.7
	Нийт дүн	360	22,976.51		30,286.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 186

Улаанбаатар
хот

Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг”-ийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсантай холбогдуулан “Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг”-ийг “Цэргийн төв эмнэлэг” болгон өөрчлөн зохион байгуулж, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулсугай.

2. Цэргийн төв эмнэлгийг улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэд, холбогдох тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цэргийн анги, байгууллагыг нэгтгэн, өөрчлөн зохион байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 122 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**

Б.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 197

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2017 оны хэмжээг тогтоох тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тогтоосугай.

2. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.12-т заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 4800 (дөрвөн мянга найман зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2016 оны хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 13 дугаар тогтоолыг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.



4. Энэ тогтоолыг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Н.НОМТОЙБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар
хот

Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 1, 8 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчлөл улсын хэмжээнд нэмэгдэж байгаатай холбогдуулан өвчний дэгдэлтийг таслан зогсоох, иргэдийг өвчлөхөөс сэргийлэх зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвийг 2017 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Бямба гараг бүрт ажиллуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2. 2017 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээрээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчид цалинтай чөлөө олгохыг ажил олгогч нарт даалгасугай.

3. Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдийн эмийн үнэд хөнгөлөлт үзүүлэх асуудлыг Нийгмийн



даатгалын үндэсний зөвлөлд тавьж шийдвэрлүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт даалгасугай.

4. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хугацаанд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны илүү цагийн хөлсөнд зориулж 104.857.000 (нэг зуун дөрвөн сая найман зуун тавин долоон мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Н.НОМТОЙБАЯР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 200003